



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/16

Амардалай

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.9. дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл 17.2.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22 -ний өдрийн 266 дугаар тогтоол "Хорио цээр, хязгаарлалтын дэглэм"-ийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журамийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Малын гоц хонины цэцэг өвчний голомт үүссэн Цахиурт багийн нутаг дэвсгэр $46^{\circ}31'08''4$ $N106^{\circ}18'22''7$ солбицол бүхий Шугамын хөх газарт 2024 оны 02 сарын 09 ний өдрөөс 14 хоногийн хугацаатайгаар 7 километрийн радиуст хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Малын гоц халдварт хонины цэцэг өвчинтэй тэмцэх урьдчилсан сэргийлэх ажилд Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг сумын Шуурхай штабын дарга (С.Нарантунгалаг)-д даалгасугай.

3. Хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс нутгийн малд үзлэг тандалт, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж ажиллахыг Дэлгэрбаяндалай Мал эмнэлгийн нэгжийн эмч (М.Даваацэрэн)-д үүрэг болгосугай.

4. Малчид иргэд олон нийтэд малын гоц халдварт мялзан өвчний талаарх мэдээллийг хүргэж, урьдчилсан сэргийлэх сургалт гарын авлага, цахим мэдээллээр хүргэж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Наранцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ



483/01037